

“ШИНЭ ШАШНЫ ХӨДӨЛГӨӨН” БУЮУ “ЁХОВАГИЙН ГЭРЧҮҮД”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ НЬ

Ц.Пүрэвсүрэн (Ph.D)

Ховд их сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал

Товч утга. Энэхүү өгүүлэлд Монголын баруун бүс нутгийн хүрээнд шашны үйл ажиллагаа явуулдаг “Еховагийн гэрчүүд”-ийн чуулганы үзэл номлолын утга санаа, шашны сургаалиа түгээж буй хэлбэр, арга аргачлал, сүсэгтнүүдийн талаар тодруулан үзэхийг хичээсэн болно. Ингэхдээ бүс нутагт хэрхэн дэлгэрсэн хийгээд явуулж буй үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөхөд оришино.

Түлхүүр үг: Библи, Есүс, Христос, шинэ шашны хөдөлгөөн, харуулын цамхаг, баптизм, усан баталгаа.

Манай шинэ Үндсэн хууль нь 1990-ээд оны Монгол Улсад улс төр, нийгэм эдийн засгийн өөрчлөлтүүд гарч байсан 1992 оны 01 сарын 13-нд тухайн үеийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын их хурлаар батлагдаж, тухайн оныхоо 02 сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөгдсөн байна. Монгол Улсын Үндсэн хууль 6 бүлэг, 70 зүйлтэй. Энэ хууль нь Монгол Улсад зах зээлийн эдийн засаг бүхий ардчилсан нийгмийг бүтээн байгуулах тогтолцооны үндсийг тавьж өгсөн төдийгүй парламентын засаглалтай бүгд найрамдах улсыг бий болгож, шашин шүтэх, эс шүтэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хүний эрх зэргийг хуульчлан баталгаажуулснаараа онцлог төдийгүй дэвшилттэй юм. Монгол оронд 1990-ээд оноос өмнө хувь хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийн чиглэлээр нэлээд хатуу бодлого баримталж ирсэн төдийгүй хүн амын дунд шашны зан үйл хийх, шашны талаар ил тод үйл ажиллагаа явуулах, сурталчлах асуудал хаалттай байсан. Хэдий ийм хаалттай мэт боловч үнэн хэрэг дээрээ ард иргэдийн дунд шашинд сүсэглэх, шашны зан үйл хийх, шашны үйлчилгээ авах, буддын шашны судар ном, бурхан тахил шүтээнээ хадгалах, түүнд сүсэглэх г.м. нь нууц далд хэлбэрээр оршин байсаар ирсэн.

Гэтэл 1990-ээд оны ардчилсан өөрчлөлттэй зэрэгцэн шашны асуудал нээлттэй болж, эрх зүйн орчин баталгаажиж, уламжлалт шашны хуучин сүм хийдүүд сэргэж, шашин номын үйл эрхлэхийн зэрэгцээ гаднын янз бүрийн шашны урсгалууд сургаал номлолоо түгээн дэлгэрүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж өнөөдрийг хүрлээ. Монгол Улс нь ардчилсан, нээлттэй нийгмийн шилжилтийн эхний жилүүдэд Үндсэн хуулийнхаа үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн төрөлжсөн хуулиудыг батлан хэрэгжүүлж эхэлсний нэг нь 1993 оны 11 сарын 11-нд батлагдсан “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” юм. Тус хуулийн дагуу Монгол Улсад олон шашны байгууллагууд зэрэгцэн оршиж, үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдсэн бөгөөд сүм, хийд шинээр байгуулах зөвшөөрөл олгох ажиллагаа 1994 оноос эхэлсэн байна. Монгол Улсад 1993 онд улсын хэмжээнд 93 сүм, хийд үйл ажиллагаа явуулж байсан¹ бол 2004 онд 225², 2016 онд 350, 2017 онд 344 сүм хийдийг тоолсон байна.³ 2017 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын 52,3 хувь нь христосын, 39,5 хувь нь буддын, 6,1 хувь нь исламын үлдсэн 2,1 хувь нь бусад чиглэлийн шашны байгууллага байна.⁴

¹ “Тадаадын болон олон улсын шашны төрийн бус байгууллагын Монгол дахь үйл ажиллагаа, үр нөлөө” судалгааны тайлан. Хууль сахиулахын их сургууль. УБ.,2017

² Нийслэлийн сүм хийд, шашны байгууллагын 2014 оны тайлан.

³ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл /www.nso.mn/. 2016.

⁴ ХЗДХ-ийн сайдын 2016 оны А/173 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн шалгалтын дүн

Харин Монголын баруун бүс нутгийн хувьд 2014 онд 48, 2015 онд 44, 2016 онд 46, 2017 онд 44, 2018 онд 47 сүм хийд тухайн жилд үйл ажиллагаа явуулсан хэмээн харьяалагдах аймгийн ИТХ-д тайлан ирүүлж, статистикийн мэдээлэлд орж тоологджээ.⁵ 2018 оны байдлаар эдгээр үйл ажиллагаа явуулж байгаа шашны байгууллагын 36.1 хувь нь буддын, 17,02 хувь нь христосын, 46,8 хувь нь исламын шашны байгууллага байна.

Эдгээрээс гадна байгууллагын буюу хуулийн этгээдийн статусаар бус хувиараа шашин, сүсэг бишрэлийн холбогдолтой зан үйл хийдэг үзмэрч, зөн билэгтэн, бөөгийн шашны удган, зайран зэрэг хүмүүс, мөн зөвшөөрөлгүй христос, болон шинэ шашны хөдөлгөөний чиглэл, чуулганууд олширсоор байна. Үүнээс дүгнэхэд Монгол Улсад шашны байгууллагуудын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр иргэдийн шашинд хандах хандлага, шашин шүтлэгийн байдал өөрчлөгдөж, улмаар нийгэм, соёл боловсрол, эдийн засгийн нэн ялангуяа монгол хүний эрхэмлэх үнэт зүйлийн хүрээнд ч хүчтэй нөлөө үзүүлэх болжээ.

Манай орны тухайд шашны асуудал нь хэдийгээр хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн боловч хуулийн хэрэгжилт, шашны байгууллагын тоо /сүм хийд/-нд анхаарах, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, тухайн шашны урсгал, чиглэл, тэдгээрийн үзэл номлолын утга агуулга, үйл ажиллагааны зорилго, үндэстний үнэт зүйлд эерэг, сөрөг ямар үйл үзүүлж буй зэрэг олон асуудлыг нэг мөр цэгцлэх, цэгцлэхийн тулд судлах, судлаачдын үгийг сонсох, өнөөдөр хэрэгжиж буй хууль эрх зүйн орчныг шинэчлэх гээд ар араасаа хөвөрсөн олон асуудлууд бий болоод байна. Энэ нь бидний өмнө шашны асуудалтай холбогдсон олон сорилтууд үүсжээ гэсэн үг. Харин үүнийг хэрхэн шийдвэрлэх бэ?

гэдэгт эхний ээлжид маш сайтар судлах, шинжлэх шаардлага буй хэмээн ойлгож болно. Тиймээс энэ удаа “шинэ шашны хөдөлгөөн”⁶-ий чиглэлд хамаарагдах “Еховагийн гэрчүүд” чуулганы талаар авч үзэхийг зорьсон болно.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөний талаар Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны тооллогын дүнд бусад гэсэн ангилалд оруулан 5 гэж тоолж ирсэн. Мөн зарим шинэ шашны хөдөлгөөний ангилалд багтдаг шашны чиглэлийг “христосын шашин” гэсэн ангилалд оруулсан байна. Нөгөө талаар тэд /шинэ шашны хөдөлгөөнийхөн/ шинэ шашны хөдөлгөөн гэсэн ангилалд хамрагдах сонирхолгүй, христос гэсэн нэг том далбаан дор үйл ажиллагаа явуулах сонирхолтой, гэтэл христосын гэгдэх чиглэлүүд нь тэднийг буруу гаж урсгал гэж үздэг, хоорондоо өрсөлддөг цаашилбал статистикийн тоо бүртгэлд бүртгэхдээ чухам аль чиглэлийг ямар ангилалд бүртгэх талаар зааж өгсөн гарын авлага, зөвлөмж байхгүй зэрэг нь энэ асуудлаарх тоо баримтууд нэгтгэн гаргахад саад учруулах төдийгүй буруу зөрүү мэдээлэл боловсруулахад хүргэж байгаа болно. Тухайлбал, баруун бүс нутагт шинэ шашны хөдөлгөөний ангилалд хамаарах баптист, мормон /ЕХХҮГ/, еховагийн гэрчүүд, бахай шашны чиглэлүүд тогтмол үйл ажиллагаа явуулдаг атал статистикийн сүүлийн 5 жилийн мэдээнд бусад гэсэн ангилалд ганц нь ч бүртгэгдэж тоологдоогүй байна. Мөн аймгийн ИТХ-д тайлангаа өгдөг боловч өмнөх жилийн тайлангаа дахин хэвлэж өгсөн, насанд хүрээгүй хүүхдэд шашин сурталчилдаг, албан ёсны зөвшөөрөл аваагүй, авсан зөвшөөрлийн хугацаа нь дууссан ч сунгуулаагүй, ялангуяа санхүүгийн тайлан маш муу /санхүүгийн эх үүсвэр нь тодорхой бус/, элдэв чуулган, цуглаан, эсийн бүлэг

⁵ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл /www.nso.mn/. 2018.

⁶ Энэ талаар Алтайбаатар. Ж., Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд //Философи, шашин судлал. №19 (475) 2017. хууд.134-144; Дэмбэрэл.С., Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь, //Философи, шашин судлал. №19 (475) 2017. хууд.104-113; Пүрэвсүрэн.Ц., Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд, ///Философи, шашин судлал. №308 (51) 2009. хууд.291-304; гэж мэт үзнэ үү.

гэсэн төөрөлдүүлсэн мэдээллээр асуудлыг аргацаан шийдвэрлэж шашин сурталчлах явдал ч түгээмэл байна. Иймд энэ бүхнийг цэгцлэх, хэдийгээр хуулиар олгогдсон эрх нь байгаа авч үүргээ биелүүлэх, хуулийн хүрээнд ажиллах шаардлага тавих цаг нэгэнт болсныг холбогдох газрууд анхаарах цаг болсон. Судлаач С.Дэмбэрэл “Албан бус тоо баримтаас үзэхэд Монголд зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй 50 орчим шинэ шашны хөдөлгөөн үйл ажиллагаа явуулж буй мэдээ байна”⁷ хэмээсэн нь асуудал ямар түвшинд байгааг илтгэх бас нэгэн баримт гэж хэлж болно.

“Библийн сургалтын төв”-өөс эрхлэн гаргасан “Теологийн товхимол”-д “еховагийн гэрчүүд”, “шинэ тэнгэр газар”, “шинэ үе хөдөлгөөн”, “авралын урсгал”, “ээж бурхны сүм” эдгээрийг бүгдийг нь гаж урсгал гэж тодорхойлоод “Гаж урсгалуудын балаг Монгол дахь христийнхнийг олон жил нийгэмд доромжлуулж, буруу ойлгуулах үндсэн хүчин зүйл болсоор ирсэн. Бүтээгч Бурханы амьд Үг болсон Библиэс харь ухагдахуунаар хүний оюуныг булингартуулж, бурханлаг ёсноос гажууд явдал, хэм хэмжээг сурталчлагчид манай улсад хэтэрч байгааг бид харж байна. Саяхан болсон улс төрийн зорилготой байж болох Мүүн шашны асуудал энэхүү гаж урсгалын талаарх асуудлыг олон түмэнд нэлээн таниулах”⁸ хэмээн дүгнэсэн байна. Хэдийгээр “шинэ шашны хөдөлгөөн”-үүдийг нийгэм судлаачдын дунд нэгд, гаж урсгал /культ/, хоёрт, шинээр төлөвшиж буй шашны чиглэлүүд гэж ойлгох хоёр янзын үзэлт бий боловч нийгэм соёлын орчин, амьдрал практикт өнөөдөр манай орны хувьд христосын шашинтнуудын дунд эдгээр нэр дурдсан чиглэлүүдийг гаж, буруу урсгал, чиглэл гэж үзэх хандлага давамгайлж байна.

“Еховагийн гэрчүүд” чуулганы ахлагч “Ховдын сүм, цуглаанууд байнга нэг нэгнээ буруутгаж өрсөлдөж байдаг. Тэгж болохгүй. Хэн нь чухам библийн шаардлагыг биелүүлж байна, үйлс нь ямар байна гэдэг нь чухал. Сүм бүхэн нэг чиглэл байсан ч өөр өөр зөвшөөрөл авна гэж ИТХ-ын шинэ журамд заасан. Шашин гэдэг нь гол зорилго нь оюун санаа, итгэлийг гэгээрүүлэх явдал. Хоол өгөх бус, хоол олж идэх аргыг нь зааж өгөх нь чухал” хэмээсэн байна.⁹

Монгол оронд тэр дундаа монголын баруун бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй Еховагийн /зарим тохиолдолд Иохавийн гэрчүүд, Ёховагийн гэрчүүд гэсэн буй/ гэрчүүд хэмээгч шашны чиглэл нь 1870 онд Пенсильванд Чарльз Тэйз Расселаар удирдуулсан библийн хичээлийн бүлгэм маягаар анх үүсэн бий болсон гэж үздэг. Рассел өөрийн бүлгээ “Мянганы Үүрийн гэгээ Библи судлал” гэж нэрлэсэн агаад нас барахаасаа өмнө зургаан боть ном бичиж үлдээсэн нь өнөөгийн “Еховагийн гэрчүүд”-ийн баримталж буй сургаал номлолын ихэнх хэсгийг бүрдүүлдэг байна. 1916 онд Расселыг нас барсны дараа түүний залгамжлагч И.Ф.Рутерфорд “Мянганы үүрийн гэгээ” цувралын “Нууц төгссөн нь” нэртэй эцсийн ботийг 1917 онд бичжээ. Чарльз Тэйз Рассел нь Долоо дахь Өдрийн Адвентист Чуулганы ахлагчийн гэр бүлээс гаралтай хүн байв. Тиймээс ч Ёховагийн гэрчүүдийг Адвентист чуулганы нэг урсгал ч гэж үздэг. Тэр христ итгэлийн гол гол үзэл баримтлалууд болох сүнс сэтгэлийн мөхөшгүй байдал, тамын гал, Гурвалын онол болон Христийн махбодын дахин ирэлт зэргийг үгүйсгэн маргалддаг байсан нь түүнийг энэхүү гаж урсгалыг бий болгох гол шалтгаан нь болжээ. Тэд Бурханыг зөвхөн Ехова гэдэг нэрээр нь дуудах ёстой гэж үздэгээрээ бас онцлог юм.

⁷ Дэмбэрэл С., Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэргэмжлэх нь, // Философи, шашин судлал. №19 (475) 2017. тал.105.

⁸ Теологийн товхимол. Пүрэвдорж Ж. //Библийн сургалтын төвийн захирал. Баярын мэдээ Христийн чуулганы тэргүүн пастор. УБ.,2016. тал.6.

⁹ Пүрэвсүрэн Ц. “Ховд аймаг дахь шашны үйл ажиллагааны талаарх судалгаа”. Хувийн архив.

“Еховагийн гэрчүүд” Есүсийг тэнгэрлэг элч Михеал буюу хамгийн дээд бүтээл гэж үздэг. Тэд итгэл, сайн үйлс болон дуулгавартай байдлыг нэгтгэн сахиж байж авралыг олж авна гэдэгт итгэдэг. Еховагийн гэрчүүд гурвалыг үгүйсгэж Есүсийг бүтээгдсэн бүтээл, ялангуяа ариун сүнснийг бурханы амьгүй хүч чадал гэж үзээд Христосын золилт, цагаатгалын үзэл баримтлалыг үгүйсгэж оронд нь төлөөсний онол буюу Есүсийн үхэл бол Адамын гэм нүглийн төлөөх төлөөс хэмээн тайлбарладаг.

“Еховагийн гэрчүүд” Есүсийг тэнгэрлэг элч Михеал буюу хамгийн дээд бүтээл гэж үздэг. Тэд итгэл, сайн үйлс болон дуулгавартай байдлыг нэгтгэн сахиж байж авралыг олж авна гэдэгт итгэдэг. Еховагийн гэрчүүд гурвалыг үгүйсгэж Есүсийг бүтээгдсэн бүтээл, ялангуяа ариун сүнснийг бурханы амьгүй хүч чадал гэж үзээд Христосын золилт, цагаатгалын үзэл баримтлалыг үгүйсгэж оронд нь төлөөсний онол буюу Есүсийн үхэл бол Адамын гэм нүглийн төлөөх төлөөс хэмээн тайлбарладаг.

Монголд үйл ажиллагаа явуулж буй Еховагийн гэрчүүд чиглэл нь <https://www.jw.org/mn/> вэб сайтаар өөрийн шашныг сурталчлахын зэрэгцээ Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Ховдод шашны байгууллага ажилладаг. Цахим хэлбэрээр хандив өргөх вэб сайттай, сайт дээр тухайн сонгосон улсын хэлээр зөвлөгөө байршуулсан байдаг. “Еховагийн гэрчүүд”-ийн хувьд <<Хүн бүр шийдсэнийхээ дагуу, харам сэтгэлээр биш, сайн дураараа өгөгтүн. Учир нь Бурхан дуртайяа өгдөг хүнийг хайрлалдаг>> [2 Коринт. 9:7] заасны дагуу хандив өргөдөг. Тэд аравны нэг өгөх эсвэл заавал хандив өргөхийг шаарддаггүй. Хандивыг заавал өргөх шаардлагагүй боловч сар бүр тогтмол хандив өргөж болно. Ингэхдээ цахимаар, банкны данснаас эсвэл биеэр очиж хандив өргөж болно. Тэдний шашнаа түгээн дэлгэрүүлэх ажил нь ихэвчлэн сайн дурын

хандиваар санхүүждэг. Цуглаанд мөнгө хураадаггүй, арван хувь авах шаардлагагүй. [Матай 10:7,8] Цалин авдаг пастор гэж байхгүй учир зардал бага гардаг. Мөн нэг ч гэрч айл өрх эсвэл хүмүүст шашнаа түгээн дэлгэрүүлснийхээ төлөө цалин хөлс авдаггүй, шүтлэгийн газраа аль болох энгийн байлгахад анхаардаг.

Ховд аймагт 2012 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 30 орчим хүн хамрагддаг, идэвхтэй явдаг 20 орчим хүн байна. Ховд аймгийн ИТХ-аас жилд нэг удаа үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан авдаг. Үүнтэй холбоотой шинэ журам батлагдсан. Сүм, цуглаанууд дэргэдээ үйл ажиллагаа явуулдаг сургалтын төв, өдөр өнжүүлэх, цэцэрлэг г.м зүйлстэй байж болохгүй заалт орсон. Тайлан авахдаа ИТХ ард иргэд, хүмүүст шашны байгууллага ямар нэгэн бодит материаллаг тусламж, мөнгө төгрөг, хандив, дэмжлэг үзүүлсэн байх ёстой гэж шаарддаг байсан. Энэ маш буруу. Монголын Еховагийн гэрчүүдийг хариуцдаг салбар нь Японд байдаг. Дэлхийн 240 гаруй улсад үйл ажиллагаа явуулдаг. Монголд Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Улаанбаатар, Ховдод байдаг.

Итгэгчийн ярианаас үзэхэд намар, хавар, зунд буюу жилд гурван удаа нэгдсэн том чуулган зохион байгуулдаг. Олон улсын хэмжээнд зохион байгуулагддаг хөтөлбөр болон бусад нь бүгд ижилхэн гардаг. Хүүхдүүд эцэг, эхээ дагаж ирдэг. Эцэг, эхээ зөвшөөрөл авна. Ямар нэгэн албадлага хэрэглэдэггүй. Шинжлэх ухаантай холбоотой шашин юм Еховагийн гэрчүүд нь. Аянга яагаад цахилдаг, морь яагаад хурдан давхидаг г.м. –ийг тайлбарласан видео хичээл үзүүлдэг. Улаанбаатар хотоос удирдана. Баруун аймгаас зөвхөн Ховд аймагт үйл ажиллагаа явуулна. Тусгай гаргасан хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулна. 7 хоногийн ням гараг 10.00, пүрэв гарагт 18.30 цагаас цуглаан тус тус болно. Зааврын дагуу жишээлбэл, хүмүүсийн сайн сайхан, эцэг, эхчүүд хүүхэдтэй, гэр

бүлийн гишүүд хоорондоо ямар харьцаатай байх, дэлхийн байдал яагаад муудаад байна г.м. асуудлаар сургалт, ярилцлага хийнэ. Итгэл, үнэмшил нарийн зөв олгож байх нь чухал. Чиглэл нь хүмүүст мэдлэг олгоод түүн дээрээ тулгуурлаж, библийн мэдлэг, ухамсар нь өөрчлөгдөж засраад, баптизм хүртээд албан ёсны гишүүн болно. Бусад нь шашныхан Есүсийг мэдэж байна уу гээд л гишүүн болгочихдог нь буруу. Тухайн хүн дунджаар 2,3,4,5 жил цуглаанд явж байж гишүүн болдог. Чухам ямар хугацаанд гишүүн болох бэ гэдэг нь тухайн хүнээс хамаардаг. Баптизмийн зан үйл нь бүтэн биеэр усанд шумбана. Баптизм хүртэх шаардлага өндөр байдаг. Бусад шашнууд хөнгөн гоомой ханддаг. Ховдод баптизм хүртсэн дөрвөн хүн байдаг. Шашны байгууллагын мөн чанарыг ИТХ ойлгодоггүй. Хүн бүхэн сонгох эрх чөлөөтэй. Сонирхсон хүн бүхнийг элсүүлэхгүй. Чуулганы мэдлэг олгодог 4-5 хүн байна. Сургалтад хамрагдаж байгаа 15-20 хүн байна. Дэлгэрүүлэх үед янз бүрийн хүмүүс хамрагддаг. Дэлгэрүүлэх гэдэг нь библийн мөн чанарыг зааж түгээнэ. Хааяа сонирхсон казах хүмүүс ирдэг. Гэвч тэд ах дүүсэг учраас ах дүү нар нь цуглаанд явлаа гэж зэмлэх, шүүмжлэх, бүр хориглож цагддаг. Бид казахууд угийн ислам шашинтай тул болохгүй гэж үздэг.

Гэрчүүд гэдэг нь Библи судалдаг нь энэ байгууллагаас үүсэлтэй. Библийг буруу орчуулж, хүмүүст буруу ойлгуулдаг. Шүтэхдээ буруу шүтдэг. Анх харуулын цамхаг гээд сэтгүүл гаргадаг байсан. Библи судрыг шинжлэх ухааны үндэстэй судалдаг байгууллагаас үүсэлтэй. Ехова гэдгийг Библид Есүсийн аав гээд орчуулсан байдаг нь зөв. Бусад нь эзэн, ертөнцийн эзэн, Есүс бурхан гэж буруу заадаг. Еховагийн нэрийг хэлж залбирдаг. Шүтлэгийн дагуу амьдардаггүй. Гэтэл бид ягштал биелүүлдэг. Олон улсын байгууллага юу зааж байна тэрийг биелүүлдэг. Тамхи хэрэглэхгүй, архийг хэтрүүлж хэрэглэхгүй. Маш ховор цөөхөн хүн явдаг, тэр болгон

хүн явж чадахгүй. Эд хөрөнгөөр татаж элсүүлэхгүй. Гол нь мэдлэг олж авах явдал. Бусдыг үгүйсгэдэггүй, буруушаадаггүй.

Еховагийн гэрч чуулганд явдаг настай эмэгтэйн хэлснээр “Өөрийгөө цэвэрхэн авч явна, бидний үед хамтын хөдөлмөртэй, хүн чанар сайн, хамтран ажилладаг, хамт олонтой байж, ядарсан үедээ олон найз нөхдөөсөө тус дэм авдаг байсан. Гэтэл одоо хүн чанаргүй, шударга ёсгүй болсон. Манай 10 жилийн төгсгөсөн ангийн багш (Увс аймагт) Улаанбаатар хотод байдаг. Энэ цуглаанд олон жил явсан. Монголд тэтгэврийн хүнийг хэн ч тоохгүй, нийгмийн дотор орохоор биднийг ашиглах, эсвэл буруу зүйлд уруу татна. Гэтэл цуглаанд явахаар ийм буруу зүйл байхгүй” гэжээ.

2019 оны 10.08-нд Улаанбаатар хотод олон улсын чуулганд болж Ховдоос 5-8 хүн оролцсон. Зардал, хоол, ундаа өөрсдөө хариуцах ёстой. Гудамжинд (давхар дэлгүүр)-т түрээсээр байрладаг байснаа болиод одоо хувийн орон сууцны байрны өрөө түрээсэлж байна. Байрыг маш сайн судалж байж сонгоно. (байрны зураг, байршил, өнгө үзэмж г.м.) Одоохондоо ахлагчгүй байгаа, цалин, мөнгө тэтгэмж авахгүй. Хандив хүсвэл өгнө, хүсэхгүй бол өгөхгүй. Хайрцагт (цуглааны хандив хийдэг 2 хайрцаг бий) мөнгө хийдэг.

“Еховагийн гэрчүүд” чиглэлийн итгэгч эмэгтэй нь өөрөө эсгий урлал, оёдол, гутал, гар урлалаар сургалт явуулж чаддаг гэнэ. Бүх оног төхөөрөмж өөрт байна. Нас ахисан учир хүнд сургахыг хичээнэ. Халамжийн байгууллагын саналаар сургалт явуулдаг. Гар урлалын зүйл борлуулалт сайтай байдаг. Монголчуудын уламжлалтай нэг их зөрчилдөхгүй. Зөрчилдвөл аль үндэслэлтэйг нь дагана. Өнөөгийн нийгэм нь хүмүүс зах зээл мэдэхгүй, голын ус үер шиг нийгэм задарсан, замбараагүй, удирдлага, зохион байгуулалт байхгүй байна. Тухайлбал, ногооны талбайд бага насны хүүхдүүд муу хүмүүсийг дагаад

эвдэрч байна. Хүүхдийн хараа хяналт муу, хүүхдүүд гар утас оролдоод эрүүл мэндээрээ хохирч байна. Өөрийн мөрөөдөл нь төгссөн мэргэжлээрээ газарзүй, математик, техник инженерээр хүн сургаж төгсгөх сонирхолтой. Гар урлал хийхээр хүний хурууны захын мэдрэмж, торгон мэдрэмж, IQ өндөр хөгждөг.

Монголчууд бүх зүйлийг өөрөө хийдэг байсан. Одоо ихэнхи нь мартагдаж байна. Монгол хэл хүртэл мартагдаж байна. Хүмүүс ногоо тарихдаа мэдлэг, туршлагагүй, мөн шуналаасаа болоод азотыг их хийж байна. Шийгуаг мөлхүүлээд болих байтал шуудуугаар урсгана. Энэ нь эрүүл мэндэд хортой. Хүмүүс мөнгө, эд хөрөнгө, гоё тавилга г.м. материаллаг зүйлд шунаж үнэтэй машин, байшин аваад өрөнд орж байна. Гэтэл энгийн амьдрал чухал, энгийн амьдрал гэдэг нь гол хэрэгцээгээ хангах, өөртөө тохирсныг хийх явдал юм.

Ховдын сүм, пуглаанууд байнга нэг нэгнээ буруутгаж өрсөлдөж байдаг. Тэгж болохгүй. Хэн нь чухам библийн шаардлагыг биелүүлж байна, үйлс нь ямар байна гэдэг нь чухал. Сүм бүхэн нэг чиглэл байсан ч өөр өөр зөвшөөрөл авна гэж ИТХ-ын шинэ журамд заасан. Шашин гэдэг нь гол зорилго нь оюун санаа, итгэлийг гэгээрүүлэх явдал. Хоол өгөх бус, хоол олж идэх аргыг нь зааж өгөх нь чухал. Санхүүжилт нь сайн дурын үндсэн дээр явагдана. Библийн II Корент номонд 9-7 зүйлд “хүн бүр зүрхэндээ шийдсэнийхээ дагуу харам сэтгэлээр биш, сайн дураар өгөгтүн. Учир нь Бурхан дуртайяа өгдөг хүнийг хайрладаг” гэсэн буй. Энэ нь хүн хүсвэл боломжоороо өг гэсэн үг. Хэн юу өгч буйг хэн ч мэдэх ёсгүй гэсэн үг. Түрээсийн мөнгө хүрэхгүй бол Японоос мөнгө өгнө. Санхүүгээ маш ухаалаг зарцуулдаг. Ном хэвлэх, түрээс төлөх, миссионер (явуулын үйлчлэгч) нарт тэтгэмж өгнө.

Эцэст нь дүгнэж үзэхэд:

1. Монголын баруун бүс нутаг дахь шашны

байгууллага /сүм хийд/-ийн талаар төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажиллах, тэдний үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

2. Орон нутагт зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй, хуулиас гадуур үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага /сүм хийд/-ийг хаах, хуулийн хариуцлага хүлээлгэх;

3. Аливаа шашин нь нийгмийн нэгдэл нягтрал, харилцан ойлголцол, ард иргэд хүмүүст ёс суртахууны үнэт зүйлийг сурталчлан таниулж байдаг боловч орон нутагт буй шашны чиглэлүүд хоорондоо нэгнээ хүлээн зөвшөөрдөггүй, итгэгч элсүүлэхийн төлөө өрсөлддөг, бусдын сул талыг хэт ашигладаг г.м. асуудал буйд анхаарах;

4. Өнөөдөр судлаачдын дунд, шашны байгууллагуудын өөрсдийнх нь хүрээнд “гаж буруу урсгал” гэж чухам ямар чиглэлүүдийг үзвэл зохилтой, хэрвээ гаж буруу чиглэлүүд нийгэмд бодитой оршин байгаад тэр нь иргэний эрх, нийтийн ашиг сонирхлын эсрэг буруу алхам хийж байвал бид яах ёстой вэ гэдэгт холбогдох байгууллагууд анхаарах хэрэгтэй;

5. Еховагийн гэрчүүд шашны чиглэл нь шинэ шашны хөдөлгөөний нэг болох нь тодорхой байна. Гэхдээ манай оронд буй шашны янз бүрийн чиглэл, урсгалууд нэгдсэн бүртгэл зөвшөөрөл байдаггүй, мөнгө санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнадаггүй, хоорондоо зөрчилддөг г.м. олон асуудлууд буйг цаашид нарийвчлан судлах;

Ном зүй

1. Алтайбаатар Х. Шинэ шашны хөдөлгөөнийг судлах арга зүйн хоёр хандлагын тухайд // Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.134-144.
2. Дэмбэрэл С. Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийн гишүүддээ нөлөөлөх арга, түүнээс сэрэмжлэх нь //Философи, шашин судлал. №19 (475). УБ.,2017. тал.104-113.
3. Пүрэвсүрэн Ц. “Монголын баруун бүс нутаг дахь шинэ шашны хөдөлгөөнүүд” //// Философи, шашин судлал. №308 (51). УБ.,2009. тал.154-164.
4. О.Чимэг. Протестант шашин. //Философи, шашин судлал. УБ., 2009.№318 тал. 55/ 93 дахь тал
5. Шинэ гэрээ. Матай. 28.18
6. Теологийн товхимол. Библийн сургалтын төв. Нийтлэгчид: Түмэнбаяр Г., Өлзийжаргал Б. ... нар. // ред. Пүрэвдорж Ж. УБ.,2016
7. <https://www.jw.org/mn/-/Еховагийн гэрчүүд> албан ёсны вэб сайт. Монгол хэл дээр/



Зураг 1. Ховд аймагт байрлах Ёховагийн гэрчүүдийн байр

Abstract: Here, a comparatively new religious direction called “Jehovah is Witnesses” turning religious operations not only in Mongolia but also in the western part of Mongolia was studied. There are many issues for religious organizations (churches) operating in local community such as propagandizing the religion with and without permission, illegally, gaining people is believes using their disadvantages, and making them become superstitious. Therefore, it is needed to focus further on updating relevant legal documents and laws.